

**ХУУЛЬ ЗҮЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2013 оны 05 сарын 8.өдөр

Дугаар A/102/169

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 313/316 дугаар тушаалаар баталсан “Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх журам”-ын 3.1.2 дахь хэсгийн заалтын “нэгдсэн эмнэлэг энэ журмын 3.1.1-д заасны дагуу шилжиж ирсэн ялтанд нарийн мэргэжлийн шинжилгээ хийж энэ журмын “хоёрт”-т заасан өвчнөөр өвчилсөн нь тогтоогдвол эмчлэгч эмч нь энэ тухай үнэн зөв баримтыг бүрдүүлж нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эмнэлэг-хөдөлмөр магадлалын комисст шилжүүлнэ. Энэ комиссыг Тогтоол гүйцэтгэх газрын даргын тушаалаар 5-аас доошгүй их эмчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна” гэснийг “нэгдсэн эмнэлэг энэ журмын 3.1.1-д заасны дагуу шилжиж ирсэн ялтанд нарийн мэргэжлийн шинжилгээ хийж энэ журмын “хоёрт”-т заасан өвчнөөр өвчилсөн нь тогтоогдвол эмчлэгч эмч нь энэ тухай үнэн зөв баримтыг бүрдүүлж нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эмнэлэг-хөдөлмөр магадлалын комисст шилжүүлнэ. Энэ комиссыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар 5-аас доошгүй их эмчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна” гэж өөрчлөн найруулсугай.

2. Энэхүү тушаалыг 2013 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн даган мөрдөж биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /хурандаа Д.Ядамдорж/-д даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

X.ТЭМҮҮЖИН



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

H.УДВАЛ

